

ШУТСангийн санхүүжилттэй “Бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, доройтлоос хамгаалах экологи-эдийн засгийн үндэслэл” төслийг МААЭШХ-тэй хамтран 2010-2012 онд хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд Бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх сэлгээний загвар, хорт чийг хамгаалах, доройтсон бэлчээрийг сайжруулах туршилт судалгааны ажлуудыг ойт хээр, хээрийн бүсийг толоолүүлэн Архангай аймгийн Ихтамир, Төв аймгийн Ондорширээт сумдын Бэлчээр ашиглагчдын хэсгүүд (БАХ) - ийг түшиглэн явуулж байна.

Дээрх сумдаас 2-3 БАХ сонгон дулааны улирлын бэлчээр сэлгэж эдлэх арга технологийг турших юм.

Төслийн нэр: “Бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, доройтлоос хамгаалах экологи-эдийн засгийн үндэслэл”

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2010-2012 он

Төслийн захиалагч: Хүнс, Ходоо аж ахуй, Хонгон үйлдвэрийн Яам

Төслийн гүйцэтгэгч: Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо (МБМХ)

Төслийн удирдагч: Доктор (Ph.D), проф.Д.Дорлигсүрэн – МБМХ-ны гүйцэтгэх захирал, эдийн засагч

Төслийн багийн гишүүд:

- Доктор (Ph.D), проф.С.Жигжидсүрэн – МБМХ-ны зөвлөх, хадлан
- бэлчээрийн агрономич
- Доктор (Ph.D), Н. Лхагважав – МБМХ-ны зөвлөх,
- Доктор (Ph.D) Д. Булгамаа - МБМХ-ны ажилтан, экологич
- Докторант Б. Болормаа - МБМХ-ны судлаач, ургамал судлаач
- Магистр У. Будбаатар - МБМХ-ны судлаач, агрономич
- Магистр Л. Отгонтуяа - МБМХ-ны судлаач, ургамал зүйч

Хамтрагч байгууллагууд:

- Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн
- Зорилтот суман дахь БАХ -үүд

Туршилт судалгааны түшиц газар:

1. Бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх сэлгээний загвар, хорсний чийг хамгаалах, доройтсон бэлчээрийг сайжруулах туршилт судалгааны ажлуудыг ойт хээр, хээрийн бүсийг толоолуулэн:

- Архангай аймгийн Ихтамир,
- Төв аймгийн Ондорширээт сумдад хийж гүйцэтгэнэ.

2. Бэлчээрийн доройтлын зэрэглэл, хорс, ургамлан номрогийн тэсвэрлэх /resistance/, сэргэх /resilience/ чадвар, босго үзүүлэлт (threshold)-ээс хамаарч сэргэх зүй тогтлыг (байгалийн бүс бүслүүрээр 30-аас доошгүй цэгт туршина)

3. Ойт хээр, хээрийн бүсэд доройтсон бэлчээрийг ургамалжуулах “Зурваслан сайжруулах”, “Ургал эрхтний трансплантаци”, “Олон наст ургамлын үр нэмэрлэн тариалах” агротехникийн туршилтыг явуулах болно.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төсөл гүйцэтгэх үндэслэл, шаардлага

Монгол орны нийт газар нутгийн 72.1 хувьтай тэнцэх 112,8 сая га байгалийн бэлчээрийн талбайн хэмжээ, ургамлын зүйлийн тоо, ургац сүүлийн жилүүдэд байгаль, уур амьсгалын ээдрээтэй оорчлолт болон зохисгүй менежментийн нолоогоор буурсаар байна. Энэ байдал малын тоо толгойг жолоодлогогүй осох ба буурах, мөн малчин, түүнийг бараадсан салбарынхны амьдрал нэн тогтворгүй болоход хүргэлээ.

Монгол орны бэлчээрийн доройтлын талаархи мэдээлэл оор хоорондоо нэлээд зөрүүтэй байна. Гэвч дийлэнхдээ 70 гаруй хувь нь доройтсон хэмээн үздэг. Гэхдээ доройтлын хэмжээ, зэрэглэлийг байгалийн бүс бүслүүрээр үнэмшилтэй тогтоож хараахан чадаагүй байна. Бэлчээрийн хорс, ургамлан номрогийн байгалийн бодит нооц, түүний оорчлолтийн чиг хандлага, оноогийн толов байдлыг зөв тогтоохгүйгээр ходоо аж ахуй, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл, ходоогийнхний талаарх торийн бодлогыг зөв тодорхойлох, хэрэгжүүлэх боломжгүй юм.

Бэлчээрийн менежментийн талаар судалгаа шинжилгээ, технологийн ажил нэлээд хийгдсэн ч оноогийн хэрэгцээ, шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байна. Зах зээлийн харилцаанд шилжсэн оноогийн ноцолд бэлчээрийг сэлгэж, системтэй, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нохон сэргээх, сайжруулах шинжлэх ухааны үндэслэлтэй арга, технологи үгчлэгдэж, бүтэц зохион байгуулалтын асуудал шийдэгдээгүй хэвээр байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны Хотолборт ходоо аж ахуйн эдэлбэр газар ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, газрын нооцийн болон толов байдлын мэдээллийн нэгдсэн сантай болох, бэлчээрийг хамгаалах, сайжруулах, тэрчлэн малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, сүргийн бүтцийг оновчтой байлгах бодлого хэрэгжүүлэхээр заажээ (Хотолборийн 2.3.6 ба 2.3.13-р заалт).

МБМХ нь бэлчээрийн тухай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, байгалийн нооцийн чадавхид үндэслэн бэлчээрийн толов байдлыг үнэлэх, малчдын хамтын нийгэмлэгт тулгуурласан бэлчээрийн менежментийн үзэл баримтлалыг боловсруулах, толовшүүлэх зэрэг үндсэн чиглэлээр ажиллаж байна. Түүнчлэн доройтсон бэлчээр, хаягдсан тариалангийн талбай, эвдэрсэн газрыг нохон сэргээх технологи боловсруулах, олон наст ургамлын торол, зүйл шалгаруулах, үр үржүүлэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх зэрэг ажлын суурийг тавьж, материаллаг баазтай болох нааштай алхмууд хийгдээд байна.

МБМХ-оос дэвшүүлж буй **“Бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, доройтлоос хамгаалах экологи-эдийн засгийн үндэслэл”** тослийн санал нь “улс орны тулгамдсан аливаа асуудлыг шийдвэрлэхэд торийн бус иргэний байгууллагуудын оролцоог хохүүлэн дэмжих” гэсэн тор, засгийн бодлогод нийцэж байна.

Төслийн эцсийн үр дүн

- 1. Бэлчээр Ашиглагчдын Хэсэг /БАХ/-т тулгуурлан, ойт хээр, хээрийн бүсийн 2000-аас дээш га бэлчээрийн ургацыг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх улирлын болон жилийн сэлгээний загвар боловсруулна.

2. Байгалийн бүс, бүслүүрт тохирсон бэлчээр сэлгэж ашиглах, сайжруулах технологийн 4-оос доошгүй зовломж.

3. Бэлчээрийн доройтлын зэрэглэл, хорс, ургамлан номрогийн тэсвэрлэх /resistance/, сэргэх /resilience/ чадвар, босго үзүүлэлт (threshold)-ээс хамаарч сэргэх зүй тогтлын ерөнхий чиг хандлагыг тодорхойлно.

4. Ойт хээр, хээрийн бүсэд доройтсон бэлчээрийг ургамалжуулах “Зурваслан сайжруулах”, “Ургал эрхтний трансплантаци”, “Олон наст ургамлын үр нэмэрлэн тариалах” агротехникийн зовломж гарна.

Төслийн үр дүнгийн шинэлэг ба дэвшилтэт тал

Экологийн талбарын үзэл баримтлал, хорс, ургамлын сэргэх чадварын онолд үндэслэн бэлчээрийн толов байдал, чанарт үнэлгээ огох, бэлчээрийн доройтлын зэрэглэл, мужлал, сэргэх зүй тогтлыг тодорхойлох нь онол, арга зүй, практикийн хувьд шинэлэг бөгөөд дэвшилтэт шийдэл болно.

Малчдын оороо ооройгоо удирдах байгууллага (Бэлчээр Ашиглагчдын Хэсэг /БАХ/-)-ыг түшиглэн бэлчээрийг доройтлоос хамгаалах, сайжруулах туршилт судалгаа явуулах, үр дүнг нэвтрүүлэхэд тослийн нийгэм, эдийн засгийн шинэлэг, дэвшилтэт тал оршино.

Төслийн шинжлэх ухаан, нийгэм, эдийн засгийн ач холбогдол

Шинжлэх ухааны хувьд: Байгаль, экологийн чадавхид үндэслэсэн бэлчээрийн толов байдал, чанарын оорчлолтийн чиг хандлагыг тодорхойлох үзэл баримтлалыг шинээр боловсруулах, мониторинг үнэлгээ, даац, ачааллыг тооцох олон улсын хэмжээнд хүлээн зовшоорогдсон цогц аргыг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, бэлчээрт экологи-эдийн засгийн үнэлгээ хийх динамик загварчлалын онолын үндэслэл боловсруулахад шинжлэх

ухааны ач холбогдол оршино.

Эдийн засгийн хувьд: Доройтсон бэлчээрийг сайжруулах арга технологийг нэвтрүүлснээр малын ашиг шим дунджаар 18-34 хувь, малчдын орлого 20 хувиар тус тус нэмэгдэх боломжтой.

Нийгмийн хувьд: Бэлчээр ашиглалтын зохистой технологи, тогтвортой менежментийг нэвтрүүлж, хэрэгжүүлснээр малчдын хамтын ажиллагааг бэхжүүлж толовшуулэх, нийгмийн капиталыг осгон нэмэгдүүлэх, ядуурал, ажилгүйдлийг бууруулахад тослийн нийгмийн ач холбогдол оршино.

Тослийн эцсийн үр дүн болох аргачлал, норматив, загвар, заавар, зовломж зэргийг МБМХ-ны түшиц газрууд болох Архангай аймгийн Ихтамир, Тов аймгийн Ондорширээт, Дундговь аймгийн Олзийт болон Завхан аймгийн бvх сумдын БАХ-ийн түвшинд нэвтрүүлнэ.